



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/580

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "д", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил" болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн хүрээнд Арвайхээр сумын Дайргын голын тариалангийн талбайг цахилгаанаар хангахад шаардагдах 80,000,000 (наян сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дайргын голын тариалангийн талбайг цахилгаанаар хангах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг зорилтот жилийн ажлын хорооны дарга (И.Доржсүрэн)-д аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д тус тус даалгасугай.

3. Дээрх зардлын 40,000,000 (дөчин сая) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101230